

ХӨВСГӨЛ АЙМГИЙН УЛААН-УУЛ СУМ ЗДТГ

Огноо: 2024-02-22

ХӨВСГӨЛ АЙМГИЙН УЛААН-УУЛ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН ТҮЛШ
ХАЛААЛТ НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ

ТӨСЛИЙН НЭР: ХӨВСГӨЛ АЙМГИЙН УЛААН-УУЛ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ТҮЛШ ХАЛААЛТ НИЙЛҮҮЛЭХ

ХАРЬЦУУЛАЛТ/
ГЭРЭЭНИЙ ДУГААР: ХӨАУУСЗДТГ/202412031

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

Огноо: **2024-02-22**
Тендер шалгаруулалтын төрөл: Бараа
Тендер шалгаруулалтын нэр: **Соёлын төв түлш халаалт**
Тендер шалгаруулалтын дугаар: **ХӨАУУСЗДТГ/202412031**
Нийт төсөвт өртөг: **32.000.000**
Тендер шалгаруулалтын арга: Харьцуулалт

Улаан-Уул сумын Засаг даргын тамгын газар нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг **Улаан-уул сумын Соёлын төвийн Түлш халаалт** нийлүүлэх тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (PDF) файлаар илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 mb, нэг файлын хэмжээ 15 mb байна. Цахим тендер зохион байгуулалт, журмын дагуу тендер оролцох хураамж 50,000 /тавин мянган/ төгрөгийг www.tender.gov.mn-ээр банкны е-меркантийн системийг ашиглан төлнө.

Үнийн санал ирүүлэх материалын техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Тендерийг **2024-02-28 -ны 15:00 цагаас** өмнө www.tender.gov.mn хаягаар ирүүлнэ. Тендерийг нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан **2024-02-28-ны 15:30 минутанд** нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх: Тооцно

Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хаяг:
Хариуцсан ажилтан: [**ХАА мэргэжилтэн Г. Шинэбаяр .**]
Хаяг: [**Хөвсгөл аймгийн Улаан-Уул сум, 5-р баг, ЗДТГ.**]
Утасны дугаар: **88946563**
Цахим шуудан: [**gantomorshinebayr423@gmail.com**]

**Хөвсгөл аймаг, Улаан-Уул
сум, 5-р баг, ЗДТГ-ын байр,
201 тоот өрөө,
утас: 88946563**

Хоёр. Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа

<p>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</p>	<p>1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа жил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх /-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.</p>
<p>2. Тендер ирүүлэх тендерийн нээлт</p>	<p>2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар ТШӨХ-д заасан огноо , цагаас өмнө хүлээн авна. 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд , ТШӨХ- д заасан газар нээлтийг хийнэ. 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн илтгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.</p>
<p>3. Тендерийн иж бүрдэл</p>	<p>3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> a) Үнийн санал b) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь c) Чадварын мэдээлэл/ санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг d) Шаардлагатай тусгай зөвшөөрөл e) Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.
<p>4. Тогтмол үнэ</p>	<p>4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.</p>
<p>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</p>	<p>5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.</p>
<p>6. Үнийн санал хүчинтэй байх хугацаа</p>	<p>6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.</p>
<p>7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх</p>	<p>7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ. 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ. 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.</p>
<p>8. Гэрээ байгуулах эрх олгох тухай тухай мэдэгдэл</p>	<p>8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залуулга болон үнийн хөнгөлөлтийг / түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт/ тооцсон тендерийн үнэ байна.</p>

Гурав. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

<p>ТШЗ-ны холбогдох заалт</p>	<p align="center">А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ</p>
<p>ТШЗ Error! Reference source not found.</p>	<p>Захиалагчийн нэр: [Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Засаг даргын тамгын газар]</p>
<p>ТШЗ Error! Reference source not found.</p>	<p>Зарлалын дугаар: [ХӨАУУСЗДТГ202412031] Тендер шалгаруулалтын нэр: [Соёлын төв Түлш халаалт] Тендер шалгаруулалтын багцын тоо болон нэр: {байхгүй }</p>
<p>ТШЗ Error! Reference source not found.</p>	<p>Санхүүжилтийн эх үүсвэр: [орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, Нийт төсөвт өртөг: [32,000,000.]</p>
<p align="center">Б.АГУУЛГА</p>	
<p>ТШЗ 9.2</p>	<p>Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хариуцсан ажилтан: [ХАА мэргэжилтэн Г. Шинэбаяр .] Хаяг: [Хөвсгөл аймгийн Улаан-Уул сум, 5-р баг, ЗДТГ.] Утасны дугаар: 88946563 Цахим шуудан: [gantomorshinebayr423@gmail.com]</p>
<p>ТШЗ Error! Reference source not found.</p>	<p>Тендер ирүүлэх өмнө уулзалт зохион байгуулах эсэх: ҮГҮЙ</p>
<p align="center">В.ТЕНДЕР БЭЛТГЭХ</p>	
<p>ТШЗ Error! Reference source not found.</p>	<p>Тендер шалгаруулалтын хэл: Монгол хэл.</p>
<p>ТШЗ Error! Reference source not found.</p>	<p>Тендерт оролцогч нь эрх бүхий эсэхээ нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> a) хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбар, b) Аж ахуйн эрхийн бичигтэй байх ба уг эрхийн бичгийн хугацаа хүчин төгөлдөр дуусаагүй байх <p>Тендерт оролцогч нь гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан захиалагчийн шаардсан чадварын шаардлагыг хангасан гэдгийг харуулах дараах мэдээллийг нотлох баримт болгон ирүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> a) Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил /2022 2023 оны санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт ирүүлнэ. b) Сүүлийн 1 жил буюу 2022 онд санал болгож буй багцын үнийн дүнгийн 80 хувиас дээш хэмжээний борлуулалтын орлоготой байсныг нотлох баримт бичиг санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт/ ирүүлнэ. c) Татвар, нийгмийн даатгал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын тодорхойлолтууд ирүүлнэ. Тодорхойлолтууд нь гаргаснаас хойш 1 сарын дотор хүчинтэй байна. Татвар, хураамж, төлбөрөө төлсөн эсхийг тендер нээсэн өдрөөр тооцно. Татвар, нийгмийн даатгал, банк, бусад байгууллагад хугацаа хэтэрсэн өр төлбөртэй, ял шийтгэлтэй болох нь аль нэг байгууллагуудаас ирүүлсэн тодорхойлолтоор нотлогдсон тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.
<p>ТШЗ Error! Reference source not found.</p>	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Огноо: [2024 он 02 сар 28 өдөр] Цаг: [15 цаг, 00 минут]</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Барааны тодорхойлолт: Манай байгууллагын захиалгат бараа нь: Тус сумын 2024 оны худалдан авалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан, Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх *Соёлын төв, Түши халаалт* Энэхүү ажлын нийт төсөвт өртөг нь **32,000,000 /гучин хоёр сая төгрөг /.**

Нийлүүлэгчийн ажлыг бэлтгэх газар нь Хөвсгөл аймгийн Улаан Уул сумын Соёлын төвт /захиалагчийн тогтоосон хаягт нь нийлүүлэн хүргэж өгнө. Энэ бараа / *Соёлын төвийн Түши халаалт* /-ыг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэхээс гадна гарал үүсэл, чанар стандарт зөвшөөрөл болон холбогдох бусад баримт бичгүүд бүгд бүрэн байна.

1. Бараа нь дараах шаардлагыг хангасан байна.

- a) Мод нь яр багатай, өмхгүй хорогдол бага гардаг
- b) 2,4 м уртгүй байх захиалагчын хүсэлтийн дагуу 35-40см урттай хөрөөдөж нарийн модыг голооор нь 1, бүдүүн модыг 6-8 хэсэгт хувааж хагалсан байх, хураалт хайрцаг тавьж эхлүүлэх, жигд эгнээ барьсан эмх цэгцтэй хураах, гарсан хогийг нэг бүрчлэн шүүрдэж цэвэрлэж овоолон ачих.

Бараа хүргэх газар: Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Соёлын төвийн заасан цэгт

2. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

СОЁЛЫН ТӨВИЙН ДАРГА *У.Х.* ДАГАРМАА



2024 ОНЫ СОЁЛЫН ТӨВИЙН ТҮЛШ ХАЛААЛТЫН МОД БЭЛТГЭХ
АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2024-01-23

№	Барааны нэр	Хөрөнгийн он	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Тоо хэмжээ		Мөнгөн дүн	Нийт үнэ	Нийлүүлэх хуваарь
						Нэг бүр	Нийт			
1	Соёлын төвийн түлшний мод бэлтгэх	Соёлын төвийн түлшний мод бэлтгэх төсөв 32,000,000 төгрөгөөр 597 метр куб мод, бэлтгэх ажлыг мэргэжлийн мод бэлтгэдэг байгууллага бэлтгэж нийлүүлнэ.								
2	Хуурай мод	2024	Өмхгүй хорогдол бага гардаг мод байна	МЗ	44600	215 м/3	597м/3	9,600,000	32,000,000	2024 оны 02 сарын 05 наас 2024 оны 06-01 хүртэл.
	Нойтон мод				58700	382 м/3		22,400,000		
3	Анхаарах зүйлс	<ul style="list-style-type: none"> • Түлээний модны уртыг 2.4 метрээс уртгүй хийж гүйцэтгэнэ. • Модыг хөрөөдөхдөө 40 см-с хэтрэлгүй хөрөөднө. • Нойтон модыг шажилж хураана. • Түлшний мод бэлтгэх санхүүжилтийг • 1р сард 8,000,000 төгрөг, • 2р сард 10,000,000 төгрөг, • 3-р сард 10,000,000 төгрөг • 4-р сард 4,000,000 төгрөг 4 хувааж ажлын гүйцэтгэлээр 100% хүртэл олгоно. 								
Нийт дүн									32,000,000	

ТӨСӨВ ГАРГАСАН: ӨВИЙН АЖИЛТАН *Б.Баттулга* Б.БАТТУЛГА

БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

[Захиалагч доорх хүснэгтийн 1-6 хүртэлх баганыг, тендерт оролцогч 7 дугаар баганыг бөглөнө]

№	Барааны нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж, тун	Барааг хүргэх эцсийн цэг	Бараа нийлүүлэх хугацаа	
					Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа)	Нийлүүлэгчийн санал болгох хугацаа (Оролцогч энэ баганыг бөглөнө)
1	2	3	4	5	6	7
1	Хуурай мод	215м/3	М3	Хөвсгөл Улаан-Уул сум Соёлын төвийн заасан цэгт	[Гэрээ байгуулснаас хойш 2024.12.31]	[6 дугаар баганад заасан хугацаанд багтаан нийлүүлэхээр санал болгож буй хугацааг бичих]
2	Нойтон мод	382м/3	М3	Хөвсгөл Улаан-Уул сум Соёлын төвийн заасан цэгт	[Гэрээ байгуулснаас хойш 2024.12.31]	

Дөрөв. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[2024-01-31]

(УЛААН-УУЛ СУМЫН ЗДТГ)-ийн дарга М.Батцогт танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан Бараа [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга

Албан тушаал, Нэр

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

НЭГ. НИЙЛҮҮЛЭГЧ	
Бараа нийлүүлэх	<p>1.1 Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.</p>
Бараа нийлүүлэх хугацаа, түүнийг сунгах	<p>1.2 Бараа нийлүүлэх хугацааг нийлүүлэлтийн хуваарийг үндэслэн ГТН-д заана.</p> <p>1.3 Нийлүүлэгч дараах нөхцөл бий болсон тохиолдолд бараа нийлүүлэлтийн хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:</p> <ul style="list-style-type: none"> а) Захиалагч ГЕН-ийн 2.4-д заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй б) Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон. <p>1.4 Захиалагч ГЕН-ийн 2.7-д заасан нөхцөлийн аль нэг нь бүрдсэн гэж үзвэл Нийлүүлэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.</p> <p>1.5 ГЕН-ийн 2.7.2-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Нийлүүлэгч нотлох үүрэгтэй.</p>
Барааг хүлээлгэн өгөх	<p>1.6 Нийлүүлэгч нь Барааг ГТН-д заасан нөхцөлөөр хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг бүрэн үзүүлж, баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.</p>
Барааны гарал үүсэл	<p>1.7 Гэрээний дагуу нийлүүлэх Бараа нь Тендерт заасан улсын гарал үүсэлтэй байна.</p> <p>1.8 Нийлүүлэгчийн Тендерийг шалгаруулахад түүнд давуу эрх олгосон бол үнэлгээний явцад үнийг нь хийсвэрээр бууруулж тооцсон аливаа бараа нь заавал Монгол Улсын гарал үүсэлтэй бараа байна.</p>
ХОЁР. ЗАХИАЛАГЧ	
Барааг хүлээн авах	<p>2.1 Захиалагч нь барааг хүлээн авч, хүлээлцсэн баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.</p>
Шалгалт, туршилт	<p>2.2 Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл явц Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт нийцэж буй эсэхийг хянах зорилгоор Захиалагч шалгалт, туршилт явуулах эрхтэй. Шалгалт, туршилт хийх хугацаа, журмын талаар Захиалагч нь Нийлүүлэгчид бичгээр урьдчилан мэдэгдэнэ.</p> <p>2.3 Шалгалт, туршилтын явцыг тэмдэглэл үйлдэн талууд баталгаажуулах бөгөөд бараа, дагалдах үйлчилгээ доголдолтой тохиолдолд Захиалагч доголдлыг арилгуулахаар Нийлүүлэгчид мэдэгдэл хүргүүлнэ.</p> <p>2.4 ГЕН-ийн 3.3-т заасан мэдэгдлийн дагуу Нийлүүлэгч барааны доголдлыг арилгах арга хэмжээ авна.</p> <p>2.5 Барааг хүлээн авахаас өмнө Захиалагч шалгасан, туршсан байх нь хүлээн авах үед түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд барааг хүлээн авахаас татгалзах, доголдолтой холбогдуулж шаардлага гаргах Захиалагчийн эрхийг хязгаарлахгүй.</p> <p>2.6 Шалгалт, туршилт хийхтэй холбоотой аливаа зардлыг Нийлүүлэгч хариуцна.</p>
Гэрээний үнэ	<p>2.7 Гэрээний үнийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.</p>

	2.8 Гэрээний үнэд хуулийн 40.4-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д заана.
Төлбөр төлөх	2.9 Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг Нийлүүлэгчид төлнө. 2.10 Нийлүүлэгчийн хүсэлтээр Захиалагч Бараа нийлүүлэх хугацааг ГЕН-ийн 2.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ. 2.11 Захиалагч нь гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон бусад холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно. 2.12 Захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй. 2.13 Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна. 2.14 Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Нийлүүлэгчид төлөх төлбөрөөс суутгана.
ГУРАВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА	
Алданги	3.1 Нийлүүлэгч нь барааг хуваарийн дагуу буюу гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө. 3.2 Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Нийлүүлэгчид төлнө.
Оюуны өмчийн эрх зөрчих	3.3 Барааг өмчлөх, эзэмших, ашиглах явцад гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.
Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал	3.4 Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Нийлүүлэгч нь энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 6.10-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно. 3.5 Нийлүүлэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна. 3.6 Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцөж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.
ДӨРӨВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ	
Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах үндэслэл	4.1 Захиалагч дараах үндэслэлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд гэрээнээс татгалзах эсхүл гэрээг цуцлах эрхтэй: а) Нийлүүлэгч гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч нэмэлт хугацаанд гүйцэтгээгүй; б) Бараа нийлүүлэх хугацаанд Нийлүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусч сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон; в) Нийлүүлэгч ГЕН-ийн 6.5-д заасан үүргээ зөрчсөн нь тогтоогдсон.

	<p>4.2 Нийлүүлэгч тендерт оролцох буюу бараа нийлүүлэх явцдаа авлига, залилан мэхлэх гэмт хэрэг үйлдсэн нь шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон.</p> <p>4.3 Захиалагч нь төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд Нийлүүлэгч гэрээг цуцалж болно.</p> <p>4.4 Нийлүүлэгч ямар ч тохиолдолд гэрээнээс татгалзах эрхийг хэрэгжүүлэхгүй.</p>
ТАВ. БУСАД ЗҮЙЛ	
Нууцлал	<p>5.1 Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.</p> <p>5.2 Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийг хамт өгнө.</p>
Мэдэгдэл	<p>5.3 Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.</p> <p>5.4 Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг ГЕН-ийн 6.9 -д зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.</p>
Гэрээнд өөрчлөлт оруулах	<p>5.5 Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй..</p> <p>5.6 ГЕН-ийн 6.15-д зааснаас бусад тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй.</p>
Маргаан шийдвэрлэх	<p>5.7 Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.</p> <p>5.8 Талууд зөвшилцөн, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.</p>

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)	1.1 [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)	2.1 Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд: <ol style="list-style-type: none"> 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь; 2) барааг хүргэсэн тухай баримт үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ; 3) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ; 4) барааны гарал үүслийн гэрчилгээ. Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5)	3.1 . Баталгаат засварын тусгай шаардлага. 3.2 . Барааны чанарын баталгааны хугацаанд нийлүүлэгчийн хүлээсэн үүргийг баталгаажуулах барьцаа хөрөнгийн хэмжээ: (Бараа нийлүүлэх гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх төгрөгийг нийлүүлэгчид олгох гэрээний төлбөрөөс захиалагч суутгана.) ⁶
4. Төлбөр (ГЕН – 7)	4.1 . Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд: Нийлүүлэгчийн төлбөрийн нэхэмжлэл, төслийн менежерийн бараа хүлээн авсан акт, захиалагчаас тогтоосон бусад баримт бичгийг захиалагч бүрэн хүлээн авснаас хойш 21 хонгийн дотор гэрээний төлбөрийг санхүүжүүлнэ. 4.2 . Барааг захиалагчийн сургуулийн хашаанд хүлээн авна. Гэрээний үнийн дүнгийн [moof] ² хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Бараа нийлүүлэх хуваарь (ГЕН – 8)	5.1 Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
6. Алданги оногдуулах (ГЕН - 9)³	6.1 Нийлүүлэгч бараа нийлүүлэлтийг дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцроож бараа нийлүүлсэн хоног тутамд 0,1 хувийн алданга төлөх бөгөөд алдангийн нийт хэмжээ 10 хувиас хэтрэхгүй байна. Алданги ноогдуулсан бол гүйцэтгэгчид олгох гэрээний үнийг нийт алдангийн хэмжээгээр бууруулан олгоно.
7. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах (ГЕН - 10)⁴	7.1 Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
8. Маргааныг (ГЕН - 11)⁵ шийдвэрлэх	8.1 Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

²Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

³ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ
[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.
Дугаар № **[Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]**

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэрийг бичих]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэрийг бичих]** (цаашид “нийлүүлэгч” гэх) нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Бараа” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны үнэ нь **[гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих]** төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Нийлүүлэгч **[Нийлүүлэгчийн нэрийг бичих]**-ийн харилцах **[Банкны нэрийг бичих]** банкны **[дансны дугаар бичих]** дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - 3.2. Нийлүүлэгч тендер илгээсэн маягт;
 - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
 - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
 - 3.5. Техникийн тодорхойлолт;
 - 3.6. Бараа нийлүүлэлтийн хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
 - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:
 - 4.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

